



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/178

Мандалговь

Газар эзэмших эрх дуусгавар болгох тухай

Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Залуус-1-100) байршилтай Дундговь аймгийн Онцгой байдлын газар (РД:9034129) -ын 1626 м<sup>2</sup> (0.16 га) газар дээр 5 давхар 20 айлын 2 блок нийтийн орон сууц барьсан тул, (4809009266) нэгж талбарын дугаартай газар эзэмших эрхийг дуусгавар болгож нийтийн эдэлбэрийн газар болгосугай.

Хоёр. Дээрх байгууллагын газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2019 оны А/216 дугаар захирамжийн Онцгой байдлын газарт холбогдох хэсэг мөн газар эзэмших (000005652) тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010489